



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

2018.01.08

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016 оны “Ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 05



дугаар албан даалгавар, Төрийн албаны зөвлөлийн “Хариуцлага, үр дүнгийн жил”-ийн зорилтыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2017 онд “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх жил” бодлогын зорилт дэвшүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн

ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу дараах байдлаар тайлагнаж байна.

Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн:

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 2017 онд 3 удаа орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонин, аймгийн www.selenge.gov.mn болон Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсаар нийтэд зарлан зохион байгууллаа. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг тухай бүр Төрийн албаны зөвлөлд хүсэлт гарган цахим хэлбэрээр явууллаа.

Мандал сумын Мишээл, Шаамар сумын 2, Ерөө, Хушаат, Сайхан сумын Номгон, Сүхбаатар сумын Сувилалын цэцэрлэгүүдийн эрхлэгч, Сүхбаатар сумын 3, 6 дугаар сургуулийн захирал, Баянгол сумын Соёлын төвийн эрхлэгч, аймгийн Насан туршийн боловсролын төвийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд 21 хүн оролцож, хамгийн өндөр оноо авсан 7 иргэн ажлын байранд тэнцсэн.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Мөн Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын даргын удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд 2 хүн оролцож, хамгийн өндөр оноо авсан нэг хүнийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох албан тушаалд нэр дэвшүүлснээр Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдон ажиллаж байна.



Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тус бүр 1 хүн оролцож шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох албан тушаалд нэр дэвшүүлснээр Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Ес. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн:

2017 онд Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 1 удаа цахим хэлбэрээр зохион байгуулан нийт давхардсан тоогоор 16 байгууллагын 32 албан тушаалд 295 иргэн бүртгүүлж **93** хүн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 160 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдлээ. Тухайн өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авч нэр дэвшсэн 3 иргэн дэс түшмэлийн ангиллын, 10 иргэн туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд



томилогдон ажиллаж байна.





Арав. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн:

Төрийн жинхэнэ албан тушаалын давхардсан тоогоор 30 сул ажлын байрыг Төрийн албаны зөвлөлийн болон аймгийн албан ёсны цахим хуудсаар ил тод нээлттэй байдлаар зарлан Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу нөөцөөс нөхөх арга хэмжээг 2017 оны 06 дугаар сарын 06-14-ний өдрүүдэд зохион байгуулан ажлын байрны тавигдах шаардлагыг хангасан 1 иргэн, мөн тус арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд зохион байгуулан ажлын байрны тавигдах шаардлагыг хангасан 4 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тухайн ажлын байранд нь томилуулахаар нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулсан.

Төрийн жинхэнэ албан тушаалын удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад нөөцөд бүртгэлтэй хүн байхгүй байна.

Аймгийн хэмжээнд төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэлтэй 177 иргэн байна. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-ийг баримтлан өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авч томилогдсон 18 иргэн, орон нутгийн харъяаллын дагуу нөөцөд бүртгэгдэн бусад аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон холбогдох баримт материалыг нь хүргүүлсэн 31 иргэн, нөөцөөс нөхөн томилсон 5 иргэнд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн сангийн мэдээллээр үйлчилсэн.

Арван нэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн:

Төрийн жинхэнэ албан тушаалын нөөцийн санд бүртгэлтэй байгаа иргэдийн хүсэлтээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох нийт 19 хүнд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийн нөөцөд бүртгэлтэй байгаа тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тодорхойлолт гаргаж өгсөн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангийн судалгаа:

№	Шалгалт болсон огноо	Сул ажлын байрны тоо	Тэнцсэн хүний тоо	1-ээр гарсан хүний тоо	Нөөцөөс нөхсөн	Шилжүүлсэн	Нөөцөд бүртгэлтэй хүний тоо
1	2016.05.09	14	67	11	1	3	42
2	2016.12.08	27	96	14	1	19	59



СЭЛЭНГЭ АЙМАГ

	2016 оны нийт	41	163	25	1	22	114
1	2017.10.06	32	93	18	3	9	63
	2017 оны нийт	32	93	18	3	9	63
	Нийт дүн	73	256	43	5	31	177

Арван хоёр. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал:



Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн шууд захирагчийн, менежерийн, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын дагуу гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, үнэлэх явцад мэргэшил, арга

зүйн удирдлагаар хангаж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг 2017 оны 01-р сарын 12, 13-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс албад, сумдын Засаг дарга, ОНӨААТҮГ-ын удирдлагууд, ойн ангийн дарга, нийгмийн салбарын үйлчилгээний байгууллагын дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарыг хамруулан өргөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, 2017-2020 оны баримталж ажиллах бодлого зорилтоо тодорхойлсон.

Тус арга хэмжээгээр аймгийн Засаг дарга эрхлэх асуудлынхаа хүрээний 22 агентлагийн төсвийн шууд захирагч нартай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилт үр дүнг тооцон ажилласан. Жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 агентлагийн дарга нараас “А” буюу “**маш сайн**” үнэлгээтэй 14, “В” буюу “**сайн**” үнэлгээтэй 8 дундаж үзүүлэлтийг тооцвол **91.7** хувийн дундаж үнэлгээтэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга буюу төсвийн шууд захирагчийн 2017 оны үр дүнгийн гэрээгээр нийт ажил үйлчилгээ 129, тусгай захиалгат ажил үйлчилгээ 17, манлайллын 6 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг





ханган ажилласныг аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчаас гэрээний биелэлтийг **90.9** хувьтай “**маш сайн**” гэж үнэллээ.

Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр төрийн албан хаагчид өөрийн харьяалах нэгжийн менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан түүний хэрэгжилтэнд улирал бүр хяналт тавьж хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс гэрээний биелэлтэнд хяналт-шинжилгээ хийж, үр дүнгийн гэрээний үнэлгээнд санал дүгнэлт өгдөг ажлыг хэвшүүлсэн.

Аймгийн нийт сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны 411 албан хаагчид 2017 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “**A**” буюу “**маш сайн**” үнэлгээтэй 174, “**B**” буюу “**сайн**” үнэлгээтэй 237, “**C**” буюу “**хангалттай**” үнэлгээтэй 28, “**D**” буюу “**дутагдалтай**” 4, “**E**” буюу “**хангалтгүй**” үнэлгээтэй 0 буюу дундаж үзүүлэлтийг тооцвол **86.3** буюу **B** үнэлгээтэй байна.

2016 оны төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагаа мэргэшлийн түвшний үнэлгээгээр хангалттай үнэлгээ авсан ахлах, дэс, туслах түшмэлийн ангиллын 110 төрийн захиргааны албан хаагчид аймгийн Засаг даргын 2017 оны А/150 тоот захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олголоо.

Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгосон байдлыг сүүлийн 10 жилийн байдлаар үзүүлбэл:

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Ахлах түшмэл	7	3	6	6	3	2	10	5	7	7
Дэс түшмэл	23	25	42	43	62	48	60	39	69	53
Туслах түшмэл	21	11	22	20	25	37	27	40	23	50
Нийт дүн	51	39	70	69	90	88	97	84	99	110

Арван гурав. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн:

Аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт 13, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад 12, нийт 25 ёс зүйн хороо шинээр томилогдон ажиллаж байна.

2017 оны жилийн эцсийн /урьдчилсан/ байдлаар аймаг, сум, агентлагийн нийт 39 төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлийн дагуу арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооноос Зүүнбүрэн, Түшиг, Шаамар, Ерөө, Алтанбулаг сумын төр, төсвийн байгууллагуудад ажиллаж буй төрийн албан



хаагчдад ёс зүйн талаар сургалт зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөмж өгч ажилласан.

Аймаг, сум, агентлагийн удирдлагууд, төрийн албан хаагчдыг хамруулсан “Төрийн алба-сахилга хариуцлага” сэдэвт зөвлөгөөнийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, аймгийн Засаг даргаас ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сахилга хариуцлагатай ажиллах талаар нийт сум, агентлагийн удирдлагууд болон төрийн албан хаагчдад үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Арван дөрөв.Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 13 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

№	Өргөдөл гаргагчийн нэр	Өргөдлийн утга	Шалгасан ажлын хэсэг	Шийдвэрлэсэн байдал
1	Т.Гантулга	Хариуцлага тооцох тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар	Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын дарга Д.Гантулга, Алтанбулаг сумын ЗДТГ-ын дарга Ү.Янжиндулам нарт ТАЗСЗ-ийн 2017 оны 11 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн.
2	С.Чойсүрэн	Ажлаас халагдсан тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Алтанбулаг сумын иргэн С.Чойсүрэнд ТАЗСЗ-ийн 2017 оны 24 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлж хуулийн байгууллагад хандахыг зөвлөсөн.
3	Н.Энхтуяа	Ажилд авахгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Шаамар сумын иргэн Н.Энхтуяад ТАЗСЗ-ийн 2017 оны 33 дугаар албан бичгээр хариуг хүргүүлж Шаамар сумын ЗДТГ-ын Төрийн сангийн гүйлгээ хариуцсан мэргэжилтнээр томилогдсон.
4	Г.Саранцэцэг	Ажлаас үндэслэлгүй	ТАЗСЗ-ийн хуралдаанаар	Баянгол сумын иргэн Г.Саранцэцэгт ТАЗСЗ-ийн 2017



СЭЛЭНГЭ АЙМАГ

		халагдсан тухай	хэлэлцсэн	оны 48 дугаар албан бичгээр хариуг хүргүүлж одоогоор эгүүлэн томилоогүй байгаа.
5	Б.Дарихжав	Засаг даргын захирамжийг хүчингүй болгох тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Б.Дарихжавд 2017 оны 50 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
6	П.Амарсанаад	Засаг даргын захирамжийг хүчингүй болгох тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	СБ сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаад 2017 оны 51 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлсэн.
7	Г.Сугар	Шүүхийн шийдвэрийг биелүүлж ажиллахгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Цагааннуур сумын сургуулийн захирал Г.Сугарт 2017 оны 53 дугаар албан бичгээр эргэн ажилд томилогдох шийдвэрийг хүргүүлсэн.
8	М.Лхамжав	Ажлаас үндэслэлгүй халагдсан тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	ТАЗСЗ-ийн 2017 оны 70 дугаар албан бичгээр үндэслэлгүй гэж үзэн хариуг хүргүүлсэн.
9	Хушаат сумын иргэн Г.Галбадрах	Н.Захирахба атарын тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Хушаат сумын иргэн Б.Галбадрахад ТАЗСЗ-ийн 2017 оны 83 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
10	Ерөө сумын “Зулзаган төгөл ойн нөхөрлөл”-өөс	Э.Ариунбат, Л.Болормаа нарын тухай		Ерөө сумын “Зулзаган төгөл ойн нөхөрлөл”-ийн ахлагч Ч.Алтантуяад ТАЗСЗ-ийн 2017 оны 34 дүгээр тогоолоор хариуг хүргүүлсэн.
11	Ч.Байгалмаа	Сахилгын шийтгэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэнд нийгмийн даатгалын байцаагч Ч.Байгалмаад ТАЗСЗ-ийн 2017 оны 33 дугаар тогтоолоор сануулах сахилгын шийтгэлийг хүчингүй гэж үзэн хариуг хүргүүлсэн.
12	Ү.Янжиндулам	Сахилгын шийтгэл	ТАЗСЗ-ийн хуралдаанаар	Алтанбулаг сумын ЗДТГ-ын дарга Ү.Янжиндуламд ТАЗСЗ-



СЭЛЭНГЭ АЙМАГ

		хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай	хэлэлцсэн	ийн 2017 оны 32 дугаар тогтоолоор сануулах сахилгын шийтгэлийг үндэслэлтэй гэж үзэж хариуг хүргүүлсэн
13	Х.Өлзийсайхан	Ажлын хэсэг томилон ажиллуулах тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн Х.Өлзийсайханд ТАЗСЗ-ийн 2017 оны 132 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн “**Selenge.gov.mn**” цахим хуудсанд байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын “**100 нүүрт Өргөн Сэлэнгэ**” сэтгүүлээр дамжуулж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Сэтгүүлийн дугаар бүрт төрийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах утас, хаяг, хариу мэдээллийг тогтмол нийтэлж 17 сум, 6 тосгонд тухай бүр хуваарилан иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж хэвшлээ.

Орон нутгийн “Миний Монгол” телевизийн “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлэгт 2017 оны 6, 12 дугаар сард Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга гишүүд оролцож, салбар зөвлөлийн үйл ажиллагааны болон төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар танилцуулж иргэдийн сонирхсон асуултанд хариуллаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн мэдээллийн самбарт Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлийн шийдвэр, цаг үеийн мэдээ, мэдээлэл, төрийн



албан хаагчдын тоо бүртгэлийн талаар болон хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний мэдээллийг байршуулж сурталчлах ажлыг тогмолжуулаад байна.

Мөн төвийн “Зууны мэдээ” сонин, Монголын үндэсний болон TV-9 телевиз орон нутгийн, “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин “Миний Монгол” кабелийн телевиз, зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс явуулж буй цаг үеийн ажил арга хэмжээний талаар ярилцлага өгч, нийтэд мэдээллэх ажлыг

зохион байгуулсан.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас санаачлан аймгуудаас анх удаа иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг багтаасан, санал, өргөдөл, гомдлоо төрийн байгууллагуудад цахимаар гаргах боломж бүхий ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ” аппликэйшнийг гаргаж, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Тус аппликэйшнийг нэвтрүүлснээр төрийн байгууллагууд иргэдийг урт дараалалд очерлуулж, бухимдал үүсгэж, чиргэдэл учруулдаг байдал тодорхой хэмжээгээр буурна гэж үзэж байгаа. Энэхүү аппликэйшнээр дамжуулан иргэд өөрийн авах үйлчилгээнийхээ талаар бүхий л мэдээллийг утсаараа дамжуулан авах боломжтойгоос гадна иргэд ухаалаг утсаа ашиглан төрийн байгууллагуудад өргөдөл, гомдлоо цахимаар гаргах боломжтой болсон. Аппликэйшнийг андройд болон айфоне төрлийн гар утастай бүх иргэд үнэ төлбөргүй татаж авч, суулгах боломжтой.



Арван зургаа. Төрийн албан хаагчийн тайлан мэдээ ирүүлсэн байдал:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс аймгийн хэмжээний төр, төсвийн байгууллагын нийт төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг суурилагдсан программын дагуу хийх заавар зөвлөмжийн талаар холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулж, тоо бүртгэл явуулах хуваарь гарган ажилласнаар төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэн аймгийн хэмжээнд 5993 /бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн 2016 оны дүнгээр/ төрийн албан хаагчийн бүртгэл бүхий нэгдсэн мэдээллийн сан бүрдүүллээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй аймгийн Гаалийн газрын 146, Цагдаагийн газрын 265 төрийн албан хаагчийн мэдээлэл харьяалах дээд шатны байгууллагадаа нэгтгэгдсэн болно.

Мэдээллийн санг ашиглан төрийн албан хаагчдад шаардлагатай төрийн албан хаагчийн биеийн байцаалт, бусад холбогдох шаардлагатай тоо баримт, мэдээллээр хангаж ажиллаж байна.

Төрийн албаны салбар зөвлөлийн самбарын мэдээллийн хэсэгт аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын тоон мэдээллийг төрийн албаны ангилал, нас, боловсрол, хүйсийн байдлаар графикаар дүрслэн байршуулж мэдээллээ.

2017 оны “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ”-г хүний нөөцийн шинэ системээр авах болсонтой холбогдуулан мэдээллийн программ хангамжийн талаар төр, төсвийн нийт байгууллагуудын дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад заавар зөвлөгөө өгч мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж ажилласнаар батлагдсан хуваарийн дагуу байгууллагынхаа төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь гүйцэтгэлээ.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Арван долоо. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн:

Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар “Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д тусгасан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад дунджаар 84.0 хувь, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 78.0 хувь, Хүний нөөцийн бодлого төлөвлөлт дунджаар 79.0 хувийн биелэлттэйгээр дүгнэгдсэн бол сумын Засаг даргын Тамгын газар Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 72.8 хувь, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 72.8 хувь, Хүний нөөцийн бодлого төлөвлөлт дунджаар 79.0 хувьтай байна.



Засаг захиргааны анхан шатны нэгж болох багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, багийн Засаг даргын үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх, Засгийн газар, аймаг орон нутгийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах асуудлуудыг тодотгох зорилгоор “Төрийн үйлчилгээ-багийн Засаг дарга” сэдэвт сургалтыг 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Манлайлал, удирдлага хөгжлийн академитай хамтран зохион байгуулж, нийт сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, холбогдох байгууллагуудын дарга нарыг хамрууллаа.



2016-2020

“ХАМТЫН ЗҮТГЭЛЭЭР ЭХ НУТГАА ХӨГЖҮҮЛБЕ”

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-БАГИЙН ЗАСАГ ДАРГА

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2017.12.06



Арван найм. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэдийн/ үнэлгээ:

Аймгийн засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар батлагдсан “Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-аар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний чанар хүртээмж, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, мэдлэг чадвар, болон төр засгаас баримтлаж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлж буй байдалд иргэдийн санал дүгнэлтийг авах, хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлохоор шийдвэрлэсэн. Сум, агентлагийн 2017 оны хэрэглэгчийн үнэлгээг тооцож үзэхэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг 0-5 оноо авахаас дунджаар 4.22, сумын Засаг даргын Тамгын газар 4.01 оноотой байна.

Цаашид хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг сайжруулах, бодитой гаргах үүднээс, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар чиглэл баримтлан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт, арга хэмжээг тусган иргэдийн оролцоог бүх талаар ханган ажиллаж байна.

Арван ес. Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх 20 үзүүлэлт”-ийн дагуу боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 347 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хамт хугацаанд нь хүргүүлсэн.

Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт:

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс судалгаа, тайлбар ирүүлэх тухай хугацаатай 16, салбар зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тогтоол, заавар, зөвлөмж 4 ирснийг бүртгэн холбогдох арга хэмжээг авч хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс 2017 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт:

№	Огноо	Дугаар	Хаанаас ирсэн	Бичгийн утга	Хэрэгжилт
Хугацаатай тайлан мэдээний тухай					
1	2017.02.01	142	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Баянгол сумын ЗДТГ-ын Нийгмийн ажилтны албан тушаалд нэр дэвшсэн Гөлөгөөжавын Цэрэнжамбын



СЭЛЭНГЭ АЙМАГ

					мэргэшлийн шалгалтын баримт бичгийг 2017 оны 21 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.
2	2017.02.21	219	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Зүүнбүрэн сумын Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд шалгалт өгч тэнцсэн Отгонбаатарын Бадамхандын мэргэшлийн шалгалтын баримт бичгийг 2017 оны 23 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
3	2017.06.15	781	Төрийн албаны зөвлөл	Сургалтад нэр дэвшүүлэх тухай	2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 56 дугаар албан тоотой хариуг хүргүүлсэн.
4	2017.06.15	777	Төрийн албаны зөвлөл	Тайлан мэдээ ирүүлэх тухай	2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 58 дугаар албан бичгээр тайлан мэдээг хүргүүлсэн.
5	2017.09.11	1017	Төрийн албаны зөвлөл	Бүтэц орон тооны судалгаа авах тухай	Бүтэц орон тооны судалгааг 2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр sudalгаа@csc.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.
6	2017.09.18	1033	Төрийн албаны зөвлөл	Чиглэл өгөх тухай	Сум, агентлагт албан тоотыг хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
7	2017.10.02	1093	Төрийн албаны зөвлөл	Өргөдөл гомдол хянан шалгуулах тухай	2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 83 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
8	2017.10.06	1111	Төрийн албаны зөвлөл	Чиглэл өгөх тухай	Холбогдох албан тушаалтанд мэдэгдэж ТАЗСЗ-ийн 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 77 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
9	2017.10.11	1129	Төрийн албаны зөвлөл	Судалгаа ирүүлэх тухай	ТАЗСЗ-ийн 2017 оны 79 дүгээр албан бичгээр төр, төсвийн 203 байгууллагын 4496 албан хаагчдаас судалгааг гаргаж



СЭЛЭНГЭ АЙМАГ

					хүргүүлэв.
10	2017.10.19	1169	Төрийн албаны зөвлөл	Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын тухай	2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
11	2017.10.24	1181	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Сайхан сумын Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хот тосгоны үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд шалгалт өгч тэнцсэн Ганболдын Мөнхмаргадын мэргэшлийн шалгалтын баримт бичгийг 2017 оны 100 дугаар албан бичгээр хүргүүлэв.
12	2017.11.08	1232	Төрийн албаны зөвлөл	Мэдээлэл хүсэх тухай	2017 оны 105 дугаар албан бичгээр сумдын төрийн албан хаагчдын сул орон тооны судалгааг гаргаж хүргүүлсэн.
13	2017.11.15	1257	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	ГХБХБГ-ын Мэдээллийн сан техник программ хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд шалгалт өгсөн Дондовдоржийн Бадрахын шалгалтын материалыг 2017 оны 110 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
14	2017.12.01	1329	Төрийн албаны зөвлөл	Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ ирүүлэх тухай	Хүний нөөцийн мэдээллийн системээр тайлан гаргах тухай ТАЗСЗ-ийн 2017 оны 118 дугаар албан бичгээр сум, агентлагийн дарга нарт хүргүүлсэн.
15	2017.12.06	1339	Төрийн албаны зөвлөл	Түр орлон гүйцэтгэгчийн тухай	Холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.



СЭЛЭНГЭ АЙМАГ

16	2017.12.06	1340	Төрийн албаны зөвлөл	Тайлан, судалгаа ирүүлэх тухай	Тайлан судалгааг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
Тогтоол, заавар, зөвлөмжийн талаар:					
1	2017.03.22	347	Төрийн албаны зөвлөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн албаны зөвлөлд хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнасан.
2	2017.04.19	482	Төрийн албаны зөвлөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.
3	2017.12.07	1346	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт зохион байгуулах аргачлалыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
4	2017.12.27	1421	Төрийн албаны зөвлөл	Шийдвэр хүргүүлэх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрийг хэрэгжүүлж ажиллалаа.

Хорин нэг. “Хариуцлага үр дүнгийн жил”-д зохион байгуулсан үйл ажиллагаа үр дүн:



Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2016 оны “Ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 05 тоот албан даалгаваруудын хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны манлайлал, мэргэшил, харилцааны түвшинг сайжруулах санал зөвлөмж гарган бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн алба-сахилга хариуцлага” сэдэвт зөвлөгөөнийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх



газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, нийт сумдын удирдлагууд болон аймгийн төвийн төрийн албан хаагчид 400 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа.

Хорин хоёр.Төрийн байгууллагуудад хууль тогтоомж, зөрчсөн үйлдлийг арилгуулах талаар зохион байгуулсан ажил:

Сэлэнгэ аймгийн “Төрийн аудитын газраас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн” аудитын тайланг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газраас гүйцэтгэл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна.

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан шаардлага, мэдэгдэл, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, дээд шатны байгууллагуудын удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаварыг хангалтгүй биелүүлсэн, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 2 байгууллагын удирдлагад аймгийн Засаг даргын захирамжаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 3 албан хаагчид хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, арга хэмжээ авлаа.


Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаа, төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 24 удаагийн зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Хорин гурав.Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хэвшил болж, үр дүнд хүрсэн шинэлэг ажил:

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтын ил тод байдлыг хангах зорилгоор иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж, хөндлөнгийн ажиглагч байлгах ажлыг тогтмолжуулаад байна.

Мөн тус шалгалтын ярилцлагын хэсэгт дуу хураагуур ашиглан шалгалтын явцыг баримтжуулж, ярилцлагын шалгалттай холбоотой санал, гомдол гарахаас урьдчилан сэргийлж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг багтаасан, санал, өргөдөл, гомдлоо төрийн байгууллагуудад цахимаар гаргах боломж бүхий ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ” аппликэйшнаар дамжуулан төрийн



- ТАНИЛЦУУЛГА
- ТАНЬД ҮЙЛЧИЛБЭ
- МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ
- ЗУРГИЙН САН
- САНАЛ ХҮСЭЛТ
- ХОЛБОО БАРИХ



албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд шуурхай хүргэж, төрийн албан хаагчтай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ